

БАТЛАВ:
МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН

**“АЛТ-2” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
“ЭХ ОРНЫХОО АЛТЫГ ЭРДЭНЭСИЙН САНДАА” АЯНЫГ 5 САРЫН
ХУГАЦААТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ УДИРДАМЖ**

2018 оны 6 дугаар сарын 04

Улаанбаатар хот

Нэг: Зорилго:

Энэхүү аяны зорилго нь аж ахуйн нэгж, байгууллага олборлосон алтаа Монголбанк, банкуудад худалдаж, алт тушаалтыг нэмэгдүүлэх, олон нийтийн дунд Монголбанк, банкны алт худалдан авах үйл ажиллагааны талаар сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, холбогдох хууль, журмыг таниулахад оршино.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг хууль, тогтоомжийн дагуу алтыг хэрхэн Төв банкиндаа худалдах, Монгол улсын гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэхийг уриалах, тэднийг холбогдох мэдээллээр хангахад чиглэгдэнэ. Мөн Монгол Улсын гаалиар зөвшөөрөлгүй алт гаргах үйлдлийг бууруулах, хариуцлагатай уул уурхайг дэмжих, тэдний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, Монголбанкны худалдан авч буй алтны үнийн талаар болон бусад мэдээллийг олон нийт, байгууллагад хүргэх, таниулах шаардлагатай гэж үзэж байна.

Үр дүнд нь Монголбанкны алт худалдан авалт болон Монгол Улсын гадаад валютын нөөц нэмэгдэж, төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоо сайжирна.

Хоёр: Хамрах хүрээ, хугацаа:

1. “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аян нь алт олборлогч, үйлдвэрлэгч аж ахуй нэгж, байгууллага, иргэн, төв, орон нутгийн холбогдох байгууллагууд руу чиглэсэн байна.

2. Аяныг Монголбанк, түүний орон нутаг дахь хэлтэс, салбар, банкууд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Стандарт хэмжил зүйн газар, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
3. “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяныг 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдрийг дуустал зохион байгуулна.
4. Аяны хүрээнд сургалт, уулзалт хийх, гарын авлага тараах, ТВ ярилцлага, нэвтрүүлэг хийх зэрэг хэлбэрээр олон нийтэд хүргэж ажиллана.

Гурав: Зохион байгуулалтын талаар

1. “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяны нээлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлаж эхлүүлнэ.

2. Аяны хүрээнд Монголбанк, түүний орон нутаг дахь хэлтэс, салбар, банкууд болон бусад оролцогч байгууллагуудтай хамтран ажиллах дэлгэрэнгүй ажлын төлөвлөгөө гаргаж ажиллана.

3. “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяныг олон нийтэд сурталчилж, танин мэдэхүйн мэдээ, мэдээллийг нийгмийн цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр түгээх, гарын авлага тараах, ТВ ярилцлага, нэвтрүүлэг, хэлэлцүүлэг, сургалт хийх зэрэг хэлбэрээр ажиллана.

Дөрөв: Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

“Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяны хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна. Үүнд:

1. Алт олборлогч аж ахуй нэгж, байгууллагын алтыг хэрхэн Монголбанкинд худалдах талаар зөв мэдээллийг дэлгэрэнгүй ойлгомжтой хэлбэрээр өгөх, тараах материал боловсруулан хүргэх,

2. Алтны гарал үүслийг тодорхой болгох тал дээр холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, хууль эрх зүйн баримт бичгийг боловсруулах,
3. Эко алтыг худалдан авч экспорлох боломжийг турших, цаашид хэрхэн ажиллах талаар судлах,
4. Алт олборлогч, худалдан авагчийн нэгдсэн платформ програм хангамжийг Ашигт малтмал, газрын тосны газар болон холбогдох төрийн байгууллагуудтай хамтран судлан боловсруулах,
5. Төв банкны цахим хуудсанд алт худалдан авалтын талаар цахим хуудас нээж, алт худалдан авалтын урьдчилсан тооцоог хийх талаар мэдээлэл өгөх,
6. Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, бусад холбогдох хууль, журмын талаар таниулах, сурталчлах, сургалт зохион байгуулж, санал солилцох,
7. Алт худалдан авч буй банктай уулзалт хийх, орон нутагт алт худалдан авах ажиллагааг эхлүүлэх талаар хамтран ажиллах,
8. Алтыг улсын хилээр зөвшөөрөлгүй гаргах гэмт хэргийн хор нөлөөлөл бусад мэдээллийг иргэд, байгууллагад өгөх, холбогдох хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах,
9. Орон нутагт алт олборлох үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж болон бичил уурхай эрхлэгчдэд алт тушаалт болон Төв банкны үйл ажиллагааны талаар газар дээрх нэгдсэн сургалтыг зохион байгуулах,
10. Үнэт металлын сорьцын хяналтын газраас алтны сорьцын шинжилгээний бичгийг онлайн горимд хүлээн авах,
11. “Алт 2” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газартай алтны олборлолтыг нэмэгдүүлэх талаар уулзалт зохион байгуулж, санал солилцож олон нийтэд хүргэх,

12. Баянхонгор, Дархан-Уул аймагт Үнэт металлын сорьцын лаборатори байгуулан, алт худалдан авах нэг цэгийн үйл ажиллагааг эхлүүлэх, холбогдох сургалт явуулах, мэдээлэл өгөх,
13. Бичил уурхайчид, алтны худалдаачдад нийлүүлэлтийн албан сүлжээний талаар сургалт зохион байгуулах, нэг цэгийн үйл ажиллагааг сурталчлах,
14. Орон нутаг дахь Монголбанкны хэлтэс, салбарын мэргэжилтнүүдэд алт худалдан авах үйл ажиллагааны талаархи сургалт зохион байгуулан, туршлагажуулах, мэдээлэл өгөх,
15. Орон нутагт алт худалдан авалтын талаар иргэдэд мэдээлэл өгөх, сургалт, сурталчилгаа явуулах,
16. Улаанбаатар хотруу орох, гарах зам дагуу мэдээлэл бүхий зурагт самбар байрлуулах,
17. Төрийн болон төрийн бус байгууллагууд дунд уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, хууль, эрх зүйн орчныг хэрхэн сайжруулах, цаашид төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог хэрхэн сайжруулах, хамтран ажиллах,

Тав: Үйл явц, үр дүнг тооцох

1. “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяны хүрээнд хамтарч ажиллах байгууллагуудын зохион байгуулсан арга хэмжээ, ажлын явц, үр дүнгийн мэдээллийг 14 хоног бүрт Баасан гаригийн 16 цагаас өмнө tsetsegsuren@mongolbank.mn цахим хаягаар хүлээн авч, ажлын үр дүнг тухай бүрт нь дүгнэж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж ажиллана.

2. Идэвхи санаачилгатай ажилласан Монголбанкны төв, орон нутаг дахь хэлтэс, салбар болон банкууд, олон нийтэд уг сэдвээр хүртээмжтэй зөв мэдээлэл хүргэсэн шилдэг сэтгүүлч, нэвтрүүлэг бүтээлийг шалгаруулж урамшуулна.

3. Аяны хэрэгжилтийн талаар нэгдсэн тайланг боловсруулж, үр дүнг холбогдох байгууллагууд болон олон нийтэд танилцуулна.

_____oO_____